УЛААНБААТАР
ХОТЫН АРДЫН ДЕПУТАТУУДЫН ХУРЛЫН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ

# ТОГТООЛ

1987 оны 7 сарын 28 өдөр

Дугаар 201

Улаанбаатар хот

хотын АДХГЗ-ын 1989 оны 161 р тогтоолоор хүчингүй

Архитектур төлөвлөлтийн газрын зохион байгуулалт, орон тоо, цалингийн тухай

БНМАУ-ын Хөдөлмөр, нийгэм хангамжийн улсын хорооны 1987 оны I55 дугаар тогтоолыг үндэслэн хотын АДХ-ын гүйцэтгэх захиргаанаас ТОГТООХ НЬ:

I. Хотын архитектур төлөвлөлтийн газар дор дурдсан хэлтэс, товчоо, албадыг байгуулж ажиллуулсугай. ҮҮНД:

а/ Хот төлөвлөлтийн хэлтэс
б/ Зураг төсвийн товчоо / Барилгын зураг, төсвийн I,2 дугаар, хот тохижилт, чимэглэлийн групптэй/
в/ Архитектурын хяналтын алба
г/ Дежурын ерөнхий төлөвлөгөөний алба

2. Архитектур төлөвлөлтийн газрын орон тоо, цалингийн хэмжээ, фондыг энэ оны 8 дугаар сарын I-ний өдрөөс эхлэн шинэчлэн хянаж бүртгэхийг Санхүүгийн хэлтэс / н.Гонгор/-т зөвшөөрсүгэй.

3. Их засварын зураг төсөв, барилга байгууламжийн газар олголтын тоо, хэмжээг төлөвлөгөөт оны урьд жилийн I2 дугаар сард багтаан хотын Санхүүгийн хэлтэст ирүүлж байхыг Архитектур төлөвлөлтийн газар / н.Жадамбаа/-т даалгасугай.

4. Энэ тогтоол гарсантай холбогдуулан " Архитектур төлөвлөлтийн газрын зохион байгуулалтын тухай" Улаанбаатар хотын АДХ-ын гүйцэтгэх захиргааны 1985 оны 7 дугаар сарын 9-ний өдрийн II3 дугаар тогтоолын I,2 дугаар зүйл, 3 дугаар зүйлийн "б" заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

БНМАУ

УЛААНБААТАР ХОТЫН АДХ-ЫН ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРГААНЫ ДАРГА С.МӨНХЖАРГАЛ

УЛААНБААТАР ХОТЫН АДХ-ЫН ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРГААНЫ ХАРИУЦЛАГАТАЙ НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА Д: АЛТАА